

Coming to terms with Buddhism

“Уучлаарай”

-Гурав дахь илбэ шиг үг-

1 сард бид “Өглөөний мэнд”, 3 сард “Баярлалаа” гэсэн илбэ шиг сайхан үгнүүдийн тухай ярьсан билээ. Үүнээс гадна хүний хоорондын харилцааны дотор бас нэгэн их чухал үг байдаг гэдгийг өнөөдөр толилуулья. Тэр үг бол “Уучлаарай” гэсэн үг юм.

Та бүхэн өөрөө буруу юм хийчихлээ гэж бодох үедээ яадаг вэ? Би бол буруугүй гэж зүтгэнэ. Яаж ийж байгаад нэг сайхан шалтгаан заая. Гэвч ингэснээр тухайн үеэ даван өнгөрөөсөн ч цаашид тэр хүнтэй сайхан харилцаатай байна гэсэн баталгаа байхгүй билээ. Гийм ч учраас алдсан үедээ өөрийнхөө бурууг шулуухан хүлээн авч “уучлаарай” гэж хэлэх нь чухал болов уу.

“Тэр буруутай”, “орчин нөхцөлийн буруу” гэж хэлмээр санагдах сэтгэлийг сайн ойлгож байна. Гэвч буддын шашинд “Найман зөв мөр” гэсэн үг байдаг билээ. Түүн дотор “Зөв үг” гэсэн сургаал байдаг. Энэ нь хүнийг муулах, хов ярихыг больж зөв үг хэрэглэх тухай сургаал билээ. “Уучлаарай” гэдэг үг нь “зөв үгийн” доторх нэгэн үг бөгөөд хүнийг хүндлэх илэрхийлэл болдог. Өөрөө үнэхээр буруутай байж дээ, болохгүй зүйл хийж орхисон гэдгээ хүлээн авч чадвал “уучлаарай” гэсэн үг өөрийн эрхгүй гарна.

Энээ тэрээ гэж тайлбар тавин, зөрүүд зан гарган ухарч байснаас шууд “уучлаарай” гээд хэлээд орхисон нь аз жаргалтай болох ойрын зам билээ. “Өглөөний

мэнд”, “баярлалаа”, “уучлаарай” гэсэн энэ гурван үгийг хэлж чаддаг байхад хүнтэй харилцах харилцаа шал өөр болоод эхлэнэ.

Дахин давтаж хэлье:

“Өглөөний мэнд”

“баярлалаа”

“уучлаарай”

гэсэн үгс хүний харилцааг сайжруулах илбэ шиг үгс юм шүү.



Төрсөн өдөр буюу Олон Улсын цэцэглэнт

Шагжатуни нь одоогоос 2500 жилийн өмнө Энэтхэгийн Рунбини гэдэг газарт олон цэцгийн дунд олон хүн ба амьтны хайрын дор хаан хүү болж төрсөн билээ. Тэр үед тэнгэрээс амтлаг бороо орж, хүүгийн биеийг ариутган угаасан юм. Хүү тэр дор босч, долоон алхам хийсний дараа “Бүх тэнгэр газрын цорын ганц хүнлэг амь” гэж хэлсэн гэдэг. Энэ нь “Энэ хорвоогийн бүх амь бол хүнлэг гайхамшигтай зүйл юм. Би үүнийг хүмүүст мэдүүлэн тайлбарлах болно” гэсэн утгатай ажээ.

РКК-д 4 сарын 8-нд Шагжамүнигийн Төрсөн Өдрийг тэмдэглэдэг бөгөөд 4 сарын 12-нд бас ИВС Олон Улсын цэцэглэнт баярыг тэмдэглэдэг байна. 14 орноос 300-гаад хүн оролцож, нийтээрээ Шагжамүнигийн төрсөн өдрийн баярыг тэмдэглэсэн билээ.



Хамтдаа суралцах нь

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч
Нивано Ничикоу

Том хүний үүрэг

Энэ онд манай нийгэмлэгийн нэгэн зорилго бол хүүхэд залуучуудын сурган хүмүүжил юм билээ. Хүүхэд залуучуудын сурган хүмүүжлийн асуудал бол ямар ч үед томчууд бидний санаа сэтгэлийг зовоодог асуудал байсан билээ.

Тэр тусмаа хүүхэд ахуй нас бол хүний амьдралын эх үндсийг тавьж өгдөг хамгийн чухал үе билээ. Тийм учраас бидэнд энэ үед хүүхдүүддээ биеэ даах сурган хүмүүжлийг олгоход их чухал үүрэг оногддог байна.

Манай улсад одоо хүүхдийн төрөлт багасаж байгаа билээ. Хүүхдийн хүн ам багасах үед нэгэн асуудал гарч ирдэг: эхчүүд хүүхдийнхээ асуудалд хэт их оролцох магадлалтай болдог байна. Хүүхдээсээ түрүүлж өмнөөс нь хийж, хүүхэд дээ бодож сэтгэх, бие хүчээ ашиглах гэсэн боломжийг нь булаадаг байна.

Мөн энэ тэр гэж байнга заадаг учраас өөрөө сэтгэж байх чадварыг нь хомсдуулдаг юм. Эдгээр зүйлүүдээс болж амархан уурладаг, хувиа хичээсэн хүүхдүүд өсч байна.

Дээр үед айл бүр олон хүүхэдтэй, эцэг эх нар ч ажилтай завгүй байсан тул хүүхэд дээ нэг бүрчлэнгээр нь анхаарч чаддаггүй байлаа. Хүүхдүүд ч тоглон наадангаа ах эгч дүү нарынхаа тусламжийн ачаар хүн болж, өөрөө өөрсдийгөө болгож, аав ээж нартаа дарамт учруулахгүй байхыг хичээдэг байлаа.

Тийм учраас эцэг эх нар бол өөрсдийнхөө гол үүргээ л биелүүлж байвал бусад асуудлыг хүүхдээрээ шийдүүлж болно. Эцэг эхийн үүрэг гэдэг бол юуны өмнө амьдралдаа хангалуун сэтгэлээр хандаж, одоо байгаа аз жаргалдаа баярлан талархаж, ямагт инээмсэглэл дүүрэн хөгжилтэй сайхан амьдрах явдал билээ.

Хүүхэд том хүнийг сайвтар ажигладаг. Бурхныхаа өмнө толгойгоо мөргөн залбирдаг эцэг эхээ хараад сурсан хүүхэд мөн л бурханд итгэдэг хүн болж өснө. Амь яваадаа баярлан талархдаг эцэг эхийн дор өссөн хүүхэд мөн л амьдралдаа талархаж чаддаг хүн болно. Юмнаас айж сандардаггүй, зовлон тоочдоггүй, үргэлж инээмсэглэж байдаг эцэг эхийн хүүхэд “Би ч гэсэн том болохоороо ээж аав шигээ болно” гэсэн бодолтойгоор өсдөг.



Хүүхдээсээ суралцах нь

Томчууд бид голцуу л хүүхэддээ заах л гэж боддог. Гэвч хүүхдээсээ бас суралцаж байх нь чухал зүйл юм. Хүүхдийн зан бол эцэг эхийн зангийг илэрхийлсэн тольтой адил гэдэг билээ. Эцэг эх нар бол гүйцэд хүн биш. Хүн зэрэгтээ хүрэхийн тулд хүүхдээсээ олныг суралцах хэрэгтэй.

Бид ариун бурхад лам нараас заалгаж суралцаж гэж боддог байхад тэд эсрэгээр хүүхдээсээ суралц гэдэг байна. Библи дотор хүүхдийн тухай хэд хэдэн сургаал байдаг: “Сэтгэлээ өөрчилж, бяцхан хүүхэд шиг сэтгэлтэй болж чадахгүй бол диваажинд хүрч чадахгүй. Бяцхан хүүхэдтэй адил өөрийгөө дор тавьж чадвал диваажинд хамгийн эрхэм хүн болж хувирана.” Энэ нь бид хүүхэдтэй адил юманд чин ариун сэтгэлээр хандаж байхыг зааж байгаа билээ. Нэрт ламын дуунд: “Бяцхан хүүхэд ухаан орох тусам Буддагаас доно. Гунигтайяа, гунигтай” гэсэн үг байдаг. Өөрөөр хэлбэл хүүхдийн ариун сайхан сэтгэлээ мартаж орхивол Буддагаас холдож орхино гэсэн үг юм.

"My journey to experience the World of Faith"?

Энэ яриаг 2009 оны 3 сарын 22-нд Гавайн нийгэмлэгийн 50 жилийн ойн баярт тэмдэглэж авсан байна.

Гавайн нийгэмлэг-Кона салбар Сүмада Риэ



Өнөөдөр манай нийгэмлэгийн 50 жилийн ойн баяр болж чин сэтгэлээсээ баярлаж байна. Ийм агуу их өдөрт өчүүхэн миний хувийн яриаг сонсон хүлээн авч буй та бүхэнд талархаж байна.

Би Кона салбарын Сүмада Риэ юм. Би 1982 онд япон гаралын гурав дахь үе болох нөхөртэйгээ танилцан суугаад Гавайн аралын Хиро хотод ирээд 16 жил амьдран сууж байна. Хоёр сайхан хүүхэдтэй болж, завгүй боловч амгалан тайван амьдарч ирсэн. Гэвч 2007 онд санаанд багтамгүй үйл явдал болж миний өдий хүртэлх амьдралд том өөрчлөгдөл гарсан. Энэ нь нэг өдөр нөхөр маань "Нэг ярилцах юм байна" гэсэн ярианаас эхэлсэн билээ. Нөхрийн яриагаар бол тэрээр өнгөрсөн 10 жилийн дотор олон эмэгтэйчүүдтэй нууцаар харилцаатай байсан юм билээ. Одоо түүнд хайртай хүүхэн байгаа бөгөөд тэр эмэгтэй нөхөртэйгээ салахаар хамт амьдрах хүсэлтэй гэдгээ ярьсан юм. Тийм учраас хоёулаа сальа гэдэг байна шүү. Би үнэхээр алмайрч орхисон. Ямар ч байсан одоо хүүхдүүдээ бодож, жаахан бодлоо сайн тунгаавал яасан бэ гэхэд нөхөр маань бид нараас илүү нууц амраг нь хамгаас илүү чухал гэдгээ ч нуусангүй. Би хэлж барашгүйгээр гайхан алмайрсан бөгөөд 10 жил гаруй нөхөртөө хуурагдан явж ирснээ бодоод үнэхээр гутсан. "Би ингэхэд юу нь байсан юм бэ? 27 жилийн амьдрал маань юу байсан юм бэ?" гэсэн асуултууд толгой дүүрэн байлаа.

Хамаг амьдралаа алдаж байгаа мэт санагдаж, би нийгэмлэгийн Хосояма даргаас зөвлөгөө авсан юм. "Би одоо яах вэ?" гэж даргаас асуухад тэр надад санаанд оромгүй зүйл хэлсэн. "Энэ хорвоогийн бүх үзэгдэл, тэр дотор зовлон ч гэсэн бүгд Буддагийн нигүүлсэхүй юм" гэсэн билээ. Би үүнд: "Наад яриаг хэд арван удаа

дуулсан. Тэглээ гээд энэ зүрхний тэлээ ердөөс тайлагдахгүй юм" гэхэд дарга: "Тэгвэл үүнд чин сэтгэлээсээ итгэж байна уу? Буддын илгээсэн үзэгдэлд сайн муу гэсэн дүн тавиагүй биз?" гэж асуусан билээ. Тэрээр үргэжлүүлэн ингэж өгүүлсэн юм: "Жинхэнэ Ертөнц нь тэрүүхэн тэнд байхад хүн тэр ертөнцийн өмнөх ганц алхамын урд зогсчихоод хэдий болсон ч давж чадалгүй зогсож байдаг юм. Тийм учраас зовдог юм. Бүх юм бол надад Бурханаас зориулсан шалгуур юм гэдгийг хүлээн авч, бүх зүйлийг Бурханд даатгах хэрэгтэй. Өдий болтол бол чамд тэр итгэл гэсэн зүйл байдаггүй байсан. Сүүлийн алхамын дэргэд Будда намайг дагуулан ирлээ. Үнэхээр талархалтай юм. Бүх зоригоо гаргаад сүүлийн даваагаа давах цаг ирлээ гэж бодох хэрэгтэй".

Яг л зураг харж байгаа юм шиг өөрийгөө харж үзсэн юм. Даргын хэлдгээр би нийгэмлэгийн хоёр дахь үеийн гишүүн байсан мөртлөө зөвхөн хэлбэр дагуйн л сүсэглэлтэй байсан юм. Ээж маань намайг 4 настай байхад нийгэмлэгт элсэж, олон хүмүүсийн төлөө буян үйлдэн гэртээ бараг байдаггүй байлаа. Тийм учраас би багадаа хайр дутуу өссөн гэж өөрийгөө өрөвдөн боддог байсан. Тиймээс ч өөрийнхөө хүүхдүүдэд тийм шаналгаа амсуулахгүй гэж хичээн нийгэмлэгийн үйл ажиллагаанд бага оролцдог байв. Гэвч өөрийнхөө алдааг ойлгосон. Ээж маань энэ нийгэмлэгт орсны ачаар би ч мөн энэ гайхамшигтай сургаалтай учирч чадсан. Шууд Японд байгаа ээж рүүгээ утасдаж, чин сэтгэлээсээ "Өдий хүртэл баярлалаа. Ээжийн насан туршдаа зүтгэн хичээсэн буддын сургаалын замыг одоо би даган явна" гэж хэлж чадсан.

Ингэж байх хооронд манай гэрийн нөхцөл байдал улам хүнд болов. Нөхөр маань том том юм ярьсан мөртлөө гэрээс шууд гарч явалгүй өдөр бүр надаар оролдон зовоож байв. Тийм амгалан тайван байсан хүн гэнэт өөрчлөгдөж, намайг элдвээр муулан гагинаж байлаа. Би даргын хэлсний дагуу бүгдийг дуугай хүлээн авч байв. Гэвч бүтэн дөрвөн сар зовлонтой өдрүүд өнгөрч байлаа. Гэсэн ч би Буддын нигүүлсэхүйд итгэн, найзыхаа сургаалын замд хөтлөн оруулж хамтдаа өдөр бүр хоёр талдаа 5 цаг зарцагдах Кона салбарын дождо хүртэл явж, мөргөл үйлдэж байлаа. Мөн миний 16 настай хүү Дэвид маань сэтгэлийн тэнхээ өгч тус болсон. Хүүгийнхээ төлөө ч гэсэн би буддын сургаалын замаар чармайлан явах хэрэгтэй гэдгээ ч ухаарсан. Хүүхдүүдтэйгээ би урьднаас илүү сайн харилцаатай болж чадсан.

Үргэжлэнэ.



